



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2022 оны эхний долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2022 оны 01-р сарын 05-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас 2 долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2022 оны эхний дугаарыг хүргэж байна. i) Олон улсын эдийн засагт өрнөж буй онцлох үйл явдлууд, ii) БНХАУ-ын эдийн засагт болсон голлох өөрчлөлт, iii) Түүхий эдийн зах зээлд гарсан өөрчлөлтийн тухай тоймлон эмхэтгэв.

1


ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ӨРНӨЖ БУЙ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

Нэг долоо хоногт бүртгэгдэх Ковид-19-ийн тохиолдол хамгийн өндөрт хүрэв

- КОВИД-19 цар тахлын Омикрон хувилбар тархаж эхэлснээр дэлхий нийтээр халдварын тохиолдлын тоо огцом өсөж сүүлийн 7 хоног¹ хамгийн их тохиолдол болох 10.1 саяд хүрсэн нь өмнө бүртгэгдсэн тохиолдлоос 2 дахин их байна. Энэхүү 10 саяыг давсан тоо нь зөвхөн албан ёсоор тест өгч бүртгэгдсэн өвчтөнүүдийн тоог харуулж байгаа бөгөөд бодит байдалд тест өгөлгүйгээр

гэрээр эмчилж байгаа өвчтөнүүд олон байгаа гэж шинжээчид таамаглаж байна. Үүнд Австрали, АНУ², Итали, Франц зэрэг нийт 20 гаруй улсад цар тахал хурдтай тархаж байгаа нь голлон нөлөөллөө. Харин КОВИД-19-н тохиолдлын тоо ихэссэн ч нас барж буй хүмүүсийн тоо сүүлийн сар гаруйн хугацаанд өмнөх 7 хоногоос буурсан трендтэй байгаа нь нааштай мэдээ болж байна.

Зураг 1. Дэлхий даяар нэг 7 хоногт илэрч буй ковидын батлагдсан тохиолдол, үүнээс шалтгаалан нас барсан хүний тоо



¹ 12-р сарын 27-оос 1-р сарын 2-ны хооронд

² 1-р сарын 4-ний мэдээгээр тус улсад нэг хоногт илрэх тохиолдол тоо 1 саяыг давж, Омикрон хувилбарын халдвар улам эрчимжсээр байна.

- Цар тахлын энэхүү илүү хүчтэй давлагаа дэгдэх болсноор нислэгүүд цуцлагдах, оффисууд хаагдах, үйлдвэрлэлийн болон нийлүүлэлтийн гинжин хэлхээнд доголдол учрах явдал түгээмэл тохиолдож байна. Энэ байдал нь дэлхийн эдийн засгийн сэргэлтийг хойшлуулах, цаашлаад 2022 оны өсөлтийн төсөөллийг сааруулах эрсдэл болж байна. Тухайлбал, Данске банкнаас 1-р сарын 5-ны өдөр Скандинавын орнуудын 2022 оны өсөлтийн төсөөллийг дээр дурдсан шалтгааны улмаас бууруулж буйгаа мэдэгдлээ.
- Одоогийн тоон мэдээллээс харахад Омикрон хувилбар нь өмнөх хувилбаруудаас аюул багатай гэсэн урьдчилсан таамаглал байгаа боловч цаашид цар тахлын тохиолдлын тоо болон нас баралтын тоо хэрхэн өөрчлөгдөхөөс 2022 оны төлөв ямар байх нь ихээхэн хамаарахаар байна.

Улс орнуудын инфляц хурдтай өсөж байна

- **Польш улсын** хувьд инфляцын түвшин 2000 он гарснаас хойших хамгийн өндөр түвшин буюу 8 хувийг давж, цаашдын төсөөлөл нэмэгдсэн нь бодлогын хүүгээ 0.5 нэгж хувиар өсгөж 2.25 хувьд хүргэх шалтгаан боллоо. Ингэснээр тус улсын хувьд шинэ он гарснаас 4 өдрийн дараа буюу энэ оны хамгийн түрүүнд хүүний шийдвэр гаргасан улс болов. Мөн 10-р сараас хойш бодлогын хүүг өсгөх шийдвэрийг 4 удаа дараалан гаргаад байна.
- **Европын бүс** нутгийн инфляц сүүлийн саруудад хурдтай нэмэгдсээр түүхэн өндөр хэмжээнд ойртож ирээд байна. Тухайлбал, Франц улсад үнийн өсөлт 12-р сард харьцангуй тогтворжсон ч цаашдын төсөөллийг харвал 2022 оны туршид өндөр байх хүлээлттэй байна.

Зураг 2. Европын бүс нутгийн инфляцын түвшин, төсөөлөл



- **АНУ-д** инфляц сүүлийн 6 сарын турш хүлээлтээс давж өсөн 2021 оны 11-р сард 6.8 хувьд хүрсэн нь 1982 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт боллоо. Инфляцын өсөлтөд шатахуун, мах, шувууны гаралтай бүтээгдэхүүний

үнийн өсөлт өндөр нөлөөтэй байв. Үүнтэй холбоотойгоор АНУ-ын Ерөнхийлөгч Жо Байден 1-р сарын 3-нд мах, шувууны гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үнийг тодорхойлогч томоохон аж ахуй нэгжүүдийн зах зээлд


нөлөөлөх хүчийг бууруулах, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх төлөвлөгөөгөө танилцуулав.

- **Турк улсад** үндэсний мөнгөн тэмдэгт болох лирагийн хямрал үргэлжлэхийн зэрэгцээ инфляцын түвшин сүүлийн 19 жилийн хамгийн өндөр түвшинд хүрээд байна. Тухайлбал, инфляцын түвшин сүүлийн 7 сар дараалан өсөж, 2021 оны 12-р сард 36 хувьд хүрсэн юм.
- **Их Британид** инфляцын түвшин сүүлийн 10 жилийн хамгийн өндөрт хүрлээ. Судалгаагаар тус улсын бизнес эрхлэгчдийн 60 орчим хувь нь ирэх 3 сарын хугацаанд инфляц нэмэгдэнэ гэж хүлээж байна.

Олон улсын тээврийн үнэ өндөр хэвээр байна

- Freightos байгууллагаас тооцож зарладаг “Дэлхийн контейнер тээврийн нэгдсэн индекс” 2021 оны 9-р сард хамгийн өндөр буюу 40 инчийн контейнер тээврийн үнэ 11'109 ам.доллар хүрч өсөж байсан бол түүнээс хойш алгуур буурч 12-р сарын 31-нд 9'293 ам.долларт хүрэв. Хэдий буурч байгаа ч энэ нь өмнөх оны мөн үеэс 2.7 дахин өндөр дүн юм. Мөн БНХАУ-ын контейнер тээврийн индекс 2021 оны сүүлийн өдрийн байдлаар түүхэн хамгийн өндөр утгад хүрч өсжээ (Зураг 3).

Зураг 3. БНХАУ-ын контейнер тээврийн индекс



Эх сурвалж: Shanghai Shipping Exchange

Эх сурвалж:

1. Bloomberg, [Weekly Covid Cases Pass 10 Million, Doubling Previous Record](#)
2. Bloomberg, [Euro Area inflation is close to peak ESB's Villeroy says](#)
3. Bloomberg, [Danske Cuts 2022 Nordic GDP Forecasts on Supply, Labor Shortages](#)
4. Bloomberg, [Poland Attacks Inflation With World's First 2022 Rate Hike](#)
5. Bloomberg, [Biden's Economic Plan, Meat Prices, Factory Activity: Eco Day](#)
6. Bloomberg, [U.S. Logs Record 1 Million Virus Cases With Data Delay](#)
7. Bloomberg, [Turkey Inflation Surges to 19-Year High](#)




2 БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ БОЛСОН ГОЛЛОХ ӨӨРЧЛӨЛТ

БНХАУ-ын үл хөдлөх салбарын онцлог

- БНХАУ-ын аж үйлдвэрийн салбарын худалдааны менежерүүдийн индекс 2021 оны 12-р сард 50.3-д хүрч өмнөх сараас 0.2 нэгжээр өслөө (Зураг 1). “Засгийн газар түүхий эд материалын үнэ тогтворжуулах арга хэмжээ³ авч үйлдвэрлэгчдэд ирэх үнийн дарамтыг бууруулсан нь энэхүү өсөлтөд голлон нөлөөллөө” хэмээн БНХАУ-ын Үндэсний статистикийн газрын ахлах статистикч Жао Чинхэг тайлбарлаж байна.

Тухайлбал, түүхий эд материалын үнийн индекс 2021 оны 12-р сард өмнөх сараас 4.8 нэгж хувиар буурч 48.1-д хүрсэн, мөн үйлдвэрээс гарах үнийн индекс 2021 оны 12-р сард өмнөх сараас 3.4 нэгж хувиар буурч 45.5-д хүрээд байна.

Зураг 3. БНХАУ-ын аж үйлдвэрийн салбарын PMI индекс



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн газар

- БНХАУ-ын Засгийн газрын зүгээс Хэнан мужид байрлах Эверграндын бүтээн байгуулж буй томоохон цогцолборыг (39 барилга) нураах шийдвэр гаргалаа. Мөн Эверграндын зүгээс Хонконгын хөрөнгийн захад хувьцаагаа арилжихыг зогсоолоо. Хэдийгээр Эверграндын зүгээс Хэнаны мега төслийг нураах Засгийн газрын шийдвэрийн талаар тайлбар өгөөгүй ч

орон нутгийн хэвлэлд энэхүү бүтээн байгуулалтыг зөвшөөрөлгүй, хууль бусаар барьж байсан хэмээн тайлбарлажээ. Эвергандаас шалтгаалж БНХАУ-ын үл хөдлөхийн томоохон компаниудын үнэлгээ унаад байна. Тухайлбал, Sunac China Holdings, Shimaо Property Holdings, Country Garden Holdings-ын хувьцаа харгалзан 10%, 7%, 3%-иар унажээ. S&P

³ Хятадын эрх баригчид нүүрс, зэс зэрэг металлууд болон бусад түүхий эд материалын

үнийг бууруулах зорилгоор улсын нөөцөөсөө зах зээлд нийлүүлж байна.



агентлагийн үзэж байгаагаар Эверграндаас шалтгаалж БНХАУ-ын үл хөдлөхийн компаниудын гуравны нэг нь ойрын нэг жилийн хугацаанд хөрвөх чадварын эрсдэлд орох магадлалтай байна.

- БНХАУ-ын зүгээс Ковидын талаар бусад улс орнуудаас ялгаатай “ТЭГ-КОВИД” бодлогыг хэрэгжүүлсээр байна. КОВИД-19 вирус анх тархаж эхлэхэд улс орнууд тархалтыг хязгаарлах зорилгоор хилээ хааж, хөл хорио тогтоох зэрэг олон хязгаарлалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Гэвч 2 жил өнгөрч цар тахлын олон шинэ хувилбарууд тархаж эхлэхэд АНУ, Англи, Австрали, Сингапур зэрэг улс орнууд цар тахалтай зэрэгцэн орших бодлогыг баримталж хязгаарлалтын арга хэмжээгээ сулласан. БНХАУ-ын хувьд КОВИД-19 вирусын ганц эерэг тохиолдол илрэхэд тухайн мужид маш хатуу хязгаарлалтын арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ нь эдийн засгийн асар том зардалтай байгаа юм.

Тухайлбал, 13 сая давсан хүн амтай Сиан хотод 12-р сарын 9-ны өдөр 143 шинэ тохиолдол бүртгэгдсэнээр нэг өрхөөс 2 хоног тутам ердөө нэг хүн хүнс авах зорилгоор гарахаас бусад хөдөлгөөнийг хязгаарлаад байна. Мөн БНХАУ-ын аж үйлдвэрийн төв болох Жөжян мужид хөл хорио тогтоосон бөгөөд тус улсын эдийн засгийн 6 орчим хувийг бүрдүүлдэг мужийн үйл ажиллагааг хязгаарлах нь эдийн засгийн маш өндөр зардалтай юм.

Эх сурвалж:

1. MacroMicro, [China Containerized Freight Index](#)
2. FF, [China's manufacturing PMI rises slightly in December 2021](#)
3. The Guardian, [China Evergrande shares suspended after order to demolish 39 buildings](#)
4. Fortune, [Evergrande suspends trading of its shares amid reports of the potential demolition of its mega island project](#)
5. VOA, [China's Zero COVID Strategy Braces for Omicron](#)
6. BBC news, [Xi'an: Chinese city under lockdown as Covid cases rise](#)

3 ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ

Коксжих нүүрсний зах зээл

- **Үнэ:** БНХАУ-ын мужуудад коксжих нүүрсний үнэ нэмэгдлээ. 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар Хэбэй мужид 1 тонн коксжих нүүрсний үнэ өмнөх гурван 7 хоногоос 100 юаниар нэмэгдэж 2760 юань (433\$), Шаньси мужид 100 юаниар нэмэгдэж 2560 юань (402\$), Тяньжин боомтод 100 юаниар нэмэгдэж 2930 юань (460\$)-д хүрээд байна.
- **Эрэлт:** БНХАУ-ын Экологи, хүрээлэн буй орчны яамнаас “Өвлийн олимптой холбоотойгоор томоохон хэмжээний хөл хорио тогтооно гэсэн яриа үндэслэлгүй болно” хэмээн мэдээлсэн,

мөн зарим мужуудад хүрээлэн буй орчны хяналтыг зөөллөснөөр ган хайлуулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаа эрчимжив. Түүнчлэн өвлийн олимпоос өмнө гангийн үйлдвэрүүд шаардлагатай коксжих нүүрсний нөөцөө нэмэгдүүлж, коксжих нүүрсний эрэлтийг дэмжлээ.

- **Нийлүүлэлт:** Шаньси мужид нүүрсний уурхайнуудын хяналт чанга хэвээр, мөн зарим уурхайнуудын жилийн төлөвлөгөө биелснээр коксжих нүүрсний нийлүүлэлт буурав. SXcoal судалгааны байгууллагын судалгаанд хамрагдсан нүүрсний үйлдвэрүүдийн



хүчин чадлын ашиглалт 12-р сарын 24-ний байдлаар өмнөх 7 хоногоос 1.8 нэгж хувиар буурч 101 хувьд хүрсэн бол 12-р сарын 31-ний байдлаар өмнөх 7 хоногоос 10.5 нэгж хувиар буурч 91 хувьд хүрээд байна.

- **Нөөц:** Нүүрсний эрэлт нийлүүлэлтээс давсны улмаас нүүрсний үйлдвэрүүдийн нөөц буурлаа. Тодруулбал, гангийн үйлдвэрүүд коксжих нүүрсний худалдан авалтаа нэмэгдүүлж, эрэлтийг нэмэгдүүлсэн бол нүүрсний уурхайнуудад хяналт чангарч, зарим уурхайнуудын жилийн төлөвлөгөө биелэж үйл ажиллагаагаа зогсоосны улмаас нүүрсний нийлүүлэлт буураад байна. Тухайлбал, SXcoal-н судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн нөөц 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар өмнөх хоёр 7 хоногоос 150 мянган тонноор буурч 810 мянган тонн болж буурсан байна.
- **Цаашдын хүлээлт:** БНХАУ-ын Экологи, хүрээлэн буй орчны яамнаас өвлийн олимптой холбоотой гангийн үйлдвэрүүдийн үйл ажиллагааг зогсоохгүй хэмээн мэдэгдсэн тул зарим

гангийн үйлдвэрүүд цаашид нэмж коксжих нүүрс худалдан авах хүлээлттэй байна. Харин дулааны улиралд хүрээлэн буй орчны хяналттай холбоотойгоор нүүрсний үйлдвэрүүд олборлолтоо нэмэгдүүлэх боломж бага тул нүүрсний үнэ өсөх хүлээлттэй байна.

Монголын нүүрсний экспорт

- Гашуунсухайт-Ганцмод боомтоор нэвтэрсэн ачааны машины хоногийн дундаж тоо 12-р сарын 25-ны байдлаар 95 байв. Хилээр нэвтрэх ачааны авто машины тоо огцом буурснаас шалтгаалж тус боомтын үнэ өнгөрсөн 7 хоногоос 60 юаниар нэмэгдэж 1760 юань буюу 277 ам.долларт хүрсэн байна.
- Шивээхүрэн-Сэхэ боомт хаалттай хэвээр байгаа бөгөөд тус боомт дээрх коксжих нүүрсний үнэ өмнөх 7 хоногоос өөрчлөгдөөгүй, 1550 юань буюу 243.1 орчим ам.доллар хэвээр байна.

Эх сурвалж:

1. *SX Coal, Weekly Update, December 21st, 2021*
2. *SX Coal, Weekly Update, January 4th Nov, 2022*
3. *Reuters, Oil settles higher despite Omicron concerns*
4. *Mining.com, Copper price rises as China's factory activity accelerates*
5. *Reuters, China intervenes to manage commodity prices*

Хүснэгт 1. Экспортын гол нэрийн түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн өөрчлөлт

Бодит гүйцэтгэл							Товч тайлбар
Үнэ (\$) 2021/12/31	Өөрчлөлт					жилийн	
	өдрийн	7 хоногийн	сарын	оны эхнээс	оны эхнээс		
Зэсийн үнэ	9,720	0.3	1.6	2.9	25.2	9720	Зэсийн үнэ 12-р сарын 31-ний байдлаар 9,720 долларт хүрэв. БНХАУ-ын аж үйлдвэрийн салбар 12-р сард сайжирч зэсийн эрэлт нэмэгдсэнээр зэсийн үнэ ийнхүү нэмэгдлээ. Нийлүүлэлт талаас дэлхийн томоохон зэсийн нийлүүлэгч болох Лас Бамбасын зэс тээвэрлэх гол замыг нутгийн иргэд 2021 оны 11-р сарын сүүлээс хойш хааж, үйл ажиллагаа нь доголдоод байсан бол 12-р сарын сүүлээр нутгийн иргэдтэй зөвшилцөлд хүрч, үйл ажиллагаагаа эргэн явуулж эхлэхээр болоод байна.
Төмрийн хүдрийн үнэ	113	0.2	0.0	18.5	-27.8	113	Төмрийн хүдрийн үнэ 113 болж нэмэгдлээ. БНХАУ-ын ардын банк мөнгөний бодлогоо зөөллөсөн, гангийн үйлдвэрүүдийн үйл ажиллагаа нэмэгдсэнээр төмрийн хүдрийн үнэ ийнхүү нэмэгдэв.
Алтны үнэ	1,829	0.8	1.0	3.1	-3.6	1,829	Алтны үнэ 12-р сарын 31-ны байдлаар 1,829 долларт хүрч өсөв. АНУ-ын инфляц 6.8 хувьд хүрч инфляцын дарамт өндөр байгаа, омикроны тархалт эдийн засагт тодорхой бус байдлыг нэмэгдүүлсэн зэргээс шалтгаалж алтны үнэ нэмэгдэв.
Газрын тосны үнэ (Брент)	78	-1.9	2.2	10.2	50.2	78	Нэг баррель Брент маркын газрын тосны үнэ 12-р сарын эцэст 78 ам долларт хүрсэн нь өмнөх сарын мөн үеэс 10.2 хувиар өссөн үзүүлэлт боллоо. Харин сарын дунджаар авч үзвэл 12-р сард 74.8 ам долларт хүрч өмнөх сараас 7.5 хувиар буурсан дүнтэй байна. Хэдийгээр КОВИД-19 цар тахлын шинэ хувилбар



						<p>тархаж улс орнууд тээвэрлэлтийн хязгаарлалт тогтоогоод байгаа ч Эквадор, Ливи, Нигери улсуудад давагдашгүй хүчин зүйлийн улмаас газрын тосны үйлдвэрүүдээ зогсоосноор АНУ-ын газрын тосны нөөц буурч, газрын тосны үнэ ийнхүү сүүлийн өдрүүдэд нэмэгдээд байна. ОПЕК+ зүгээс омикрон хувилбарын нөлөө богино хугацаанд үргэлжилж, төдийлөн хүчтэй нөлөө үзүүлэхгүй тул төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулахгүй гэсэн байр суурьтай байна.</p>
--	--	--	--	--	--	---